



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/15

Хэрлэнбаян-Улаан тосгон

Хагас жилийн мал тооллого явуулах тухай

Монгол Улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 25 дугаар зүйлийн 25.1, “Статистикийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “в” дэх заалт, “Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2025 оны А/319 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тосгоны хэмжээнд 2025 оны хагас жилийн мал тооллогыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 06 дугаар сарын 09-ний өдрүүдэд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ю.Батбаяр – Нягтлан бодогч

Гишүүд: Д.Болормаа – ХХААхуйн мэргэжилтэн

О.Эрдэнэбат – Жолооч

2. Хагас жилийн мал тооллогын ажлыг хугацаанд нь чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ю.Батбаяр)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн ажлын албаны дарга (С.Отгонбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧ



Б.ЭНХЦЭЦЭГ